



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.04.20 № 48
танай _____-ны № _____-г

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.10, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2026 оны Архангай аймгийн Эрдэнэбулган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох "Ардчилсан нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Эрдэнэбулган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын газар нь Эрдэнэбулган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Эрдэнэбулган сумын “Ардчилсан нам”-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Эрдэнэбулган сумын “Ардчилсан нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр ... хуудсыг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



T. Baygalmaa

Т.БАЙГАЛМАА



“2026 ОНЫ ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ИТХ-ЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР”

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЦЭЦЭРЛЭГ ХОТ



ЗОРИЛТ: “Хүүхдэд ээлтэй хот, орон нутаг” олон улсын санаачилгыг 20 жилийн өмнөөс эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд дэлхийн 40 гаруй улс хамрагдаад байна. Хүүхдэд ээлтэй хот, орон нутаг санаачилга нь Хүүхдийн эрхийн конвенцид тунхагласан хүүхдийн эрхийг хангах орон нутгийн засаглалын тогтолцооны загвар бөгөөд орон нутгийн удирдлага нь хүүхдийн дуу хоолой, тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэн хүүхдийн эрхийн асуудлыг бүх бодлого хөтөлбөр, төсөвтөө тусган ажиллахыг хэлнэ. Хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлснээр эцэг, эх гэр бүлийн гишүүд санаа амар үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, хөдөлмөрлөх, ая тухтай орчинд амьдрах цогц шийдлийг бий болгож, нийт иргэдийн амьдралын чанарыг нэмэгдүүлэх юм.

1. ЧИНЭЭЛЭГ ХОТ

- Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилготой тусгайлсан бүтээгдэхүүнүүдийг бий болгоно.
- “Архангай” брэндийн нэгдсэн шошго, тэмдгийг нэвтрүүлж, үндэсний болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай кластер тогтолцоог хөгжүүлнэ.
- Нутгийн иргэдийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлттэй, уян хатан нөхцөлийг бүрдүүлнэ.
- Аялал жуулчлалын салбарын нэгдсэн бодлогын хүрээнд бий болох орлого, татварын тодорхой хувийг орон нутагт төвлөрүүлэх тогтолцоог хэрэгжүүлнэ.
- Аялал жуулчлалын байгууллагуудад нутгийн иргэдийг ажиллуулах, оролцоог нь нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.

2. НОГООН ХОТ

- Өрх бүрийг бие даасан, байгальд ээлтэй эрчим хүч, дулаалга, цэвэр болон бохир усны шийдлээр хангах тогтолцоог дэмжиж ажиллана.
- Цэцэрлэг хотын ногоон байгууламжийг эрс нэмэгдүүлж, нийтийн орон зайг ухаалгаар төлөвлөн, бүх насны иргэдэд хүртээмжтэй, тав тухтай орчин бүрдүүлнэ.
- 2012–2016 онд хэрэгжүүлсэн “Гудамж” төсөл болон бусад дэд бүтцийн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хөгжүүлнэ.

3. ОЮУНЛАГ ХОТ

- Багш, ажилтны тоог нэмэгдүүлэх замаар ажлын ачааллыг бууруулж, нийгмийн баталгааг сайжруулна.
- Сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын үндсэн хөтөлбөрөөс гадна ур чадвар хөгжүүлэх, олон нийтийн оролцоонд тулгуурласан нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- Боловсролын салбарт сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллана.



4. ТАЙВАН ХОТ

- Хүүхдүүд аюулгүй, бие даан зорчих нөхцөлийг бүрдүүлэх замын тэмдэг, тэмдэглэгээ, дэд бүтцийг сайжруулж, хяналтын камер бүхий аюулгүй орчныг цогцоор нь төлөвлөж хэрэгжүүлнэ.
- Хүүхэд хамгаалал, гэр бүлийн чиглэлээр ажиллах нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн орон тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.
- Хүүхдийн оролцоог дэмжсэн, тэдний дуу хоолойг бодлого, шийдвэр гаргалтад тусгасан, хэрэгжилтийг бодитоор хангадаг тогтолцоог бий болгоно.

5. ЭРҮҮЛ ХОТ

- Цэцэрлэг хотын иргэдэд чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулж, үйлчилгээний тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Эмч, эмнэлгийн ажилтны, ажлын ачааллыг бууруулан, нийгмийн баталгааг сайжруулна.
- Зүрх, судас болон хоол боловсруулах тогтолцооны өвчний эрт илрүүлэг, оношилгоог тогтмолжуулж, чанар хүртээмжийг сайжруулна.
- Цэцэрлэг, сургуулийн орчинд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол хэрэгжүүлнэ. Эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлыг нэмэгдүүлэн, эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлнэ.

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН АРДЧИЛСАН НАМ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026. 04. 20 № 217
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЧУЛУУТ
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.10, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2026 оны Архангай аймгийн Чулуут сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох "Ардчилсан нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Чулуут сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын газар нь Чулуут сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Чулуут сумын “Ардчилсан нам”-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Чулуут сумын “Ардчилсан нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр ... хуудсыг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЦЭЦЭРЛЭГ ХОТ

ЗОРИЛТ: НҮБ-ийн хүүхдийн сангаас “Хүүхдэд ээлтэй хот орон нутаг” олон улсын санаачилгыг 20 жилийн өмнөөс эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд дэлхийн 40 гаруй улс хамрагдаад байна. Хүүхдэд ээлтэй хот, орон нутаг санаачилга нь Хүүхдийн эрхийн конвенцэд тунхагласан хүүхдийн эрхийг хангах орон нутгийн засаглалын тогтолцооны загвар бөгөөд орон нутгийн удирдлага нь хүүхдийн дуу хоолой, тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэн хүүхдийн эрхийн асуудлыг бүх бодлого хөтөлбөр, төсөвт тусган ажиллахыг хэлнэ. Хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлснээр эцэг эх гэр бүлийн гишүүд сэтгэл амар үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, хөдөлмөрлөх, ая тухтай орчинд амьдрах цогц шийдлийг бий болгож, нийт иргэдийн амьдралын чанарыг нэмэгдүүлэх юм.

1. ЧИНЭЭЛЭГ СУМ

- ✓ Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бүтээгдэхүүн гаргахад дэмжлэг үзүүлж ажиллана.
- ✓ Чулуут нутгийн брэнд бүтээгдэхүүний шошго, тэмдэг нэвтрүүлж, үндэсний хэмжээнд болон гадаад зах зээлд түгээх боломж бий болгохын төлөө ажиллана.
- ✓ Нутгийн иргэдийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэхэд татварын хөнгөлттэй нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн орчиныг бүрдүүлэх.
- ✓ Аялал жуулчлалын байгууллагад нутгийн иргэдтэй ажиллах боломжийг бүрдүүлж ажиллана.

2. НОГООН СУМ:

- ✓ Өрх бүрд бие даасан, ногоон шийдэл бүхий эрчим хүч, цэвэр бохир усны хангамжийг бүрдүүлэхэд дэмжиж ажиллах.
- ✓ Чулуут сумын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчиныг бүрдүүлэх.

3. ОЮУНЛАГ СУМ:

- ✓ Сургууль болон сургуулийн өмнөх боловсролын стандарт цагаас гадна ур чадвараа хөгжүүлэх олон нийтийн оролцоотой хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- ✓ Хүүхдийн сургалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор боловсролын салбарыг дэмжиж ажиллана.
- ✓ Залуучуудыг орон нутагтаа ажиллаж, амьдрах нөхцөлөөр хангана.

4. ТАЙВАН СУМ:

- ✓ Хүүхдүүд аюулгүй, тайван зорчих, бие даан сургууль, цэцэрлэгтээ очих боломжийг бүрдүүлсэн замын тэмдэглэгээ, орчныг бүрдүүлж, аюулгүй байдлыг хангах.
- ✓ Хүүхэд хамгаалал болон гэр бүлийн чиглэлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдтэй хамтран оролцоог нэмэгдүүлнэ.
- ✓ Аливаа шийдвэрт хүүхдийнхээ дуу хоолойг сонсдог, оролцоог дэмждэг бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.ЭРҮҮЛ СУМ:

- ✓ Чулуут сумын иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээ сайжруулах чиглэлээр бодлого хэрэгжүүлнэ.
- ✓ Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж ажиллана.
- ✓ Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ

